

С.Цоггэрэл

Цагаандай
Цоохондой
хоёр



С.Цоггэрэл

Цагаандай Цоохондой хоёр

Сургуулийн бага насныханд
зориулсан өгүүллэгүүд



Улаанбаатар хот
2007 он

С.Цоггэрэл
ЦАГААНДАЙ ЦООХОНДОЙ ХОЁР

Сургуулийн бага насныханд зориулав.

Зураач Н.Хүдэрчулуун

Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа
Хянагч Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдалгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Үзэсгэлэнд болсон явдал

Хүүхдийн баяр боллоо. Би дөрвөн настай дүү Энхболд, зургаан настай дүү Энхбаяр хоёрыгоо дагуулаад хүүхдийн уран бүтээлийн үзэсгэлэн үзэхээр явах болов. Аав, Энхболдыг хувцаслаж байхдаа надад:

- Энэ хоёр аварга ч миний хүүг зовоох вий дээ. Гэрлэн дохио харж байж зам гараарай! Хоёр дүүгээ гараасаа салгаж болохгүй шүү. Үзэсгэлэнд орсон хойноо ч гэсэн гараасаа





битгий салгаарай, юм хүмий нь унагааж барих вий! гэж захисаар үлдэв.

Үзэсгэлэнд олон янзын зураг, баримал, сийлбэр, сүрлээр хийсэн сав суулга гээд л олон сонин гоё зүйлүүд тавьсан байлаа. Бид нарт ч тэр бүгдийг барьж үзэх юм сан гэсэн хүсэл төрсөн ч аавын хэлснийг санаж тэвчсээр явав. “Чамайг даа” киноны туулайг шаар бариад бөмбөр цохиж явахад нь чоно араас нь арзгар шүдтэй амаа ангайн түүнийг барих гэж байгаа хэсгийг нь баримлаар хийж тавьсан нь их л аймшигтай харагдав. Энхболд түүнийг хармагцаа л:

- Чи яагаад энэ хөөрхөн туулайг идэх гээд байгаа юм бэ? гэж хэлэнгүүтээ нөгөө чонын толгойг нь базаад авлаа. Үзэсгэлэнгийн тайлбарлагч эгч харчхаад бидэн дээр хүрч ирээд:



- Та нар яагаад үүнийг эвдчихэв? Бушуухан буцааж байснаар нь засаж тавь! гэж загнав. Би ч айсандаа арай гэж л нэг юм засаж өгөхөд нөгөө эгч:

- Хэзээ ийм чоно байсан юм. Та нар дахиад үзвэрүүдийг битгий эвдчихээрэй! гэж зандарлаа. Энхбаяр:

- Энэ эгч ийм олон гоё юм хийдэг мундаг эгч байна, тийм ээ? гэж надаар тийм гэж хэлүүлэх гэсэндээ зогсоо зайгүй шалгааж явлаа. Би ч хоёр дүүгийнхээ гараас чанга гэгч нь атгаж, цааш явтал сур харваж, бөх барилдаж, морины уралдаан гээд олон гоё юм байв. Би ингээд уралдааны морь унавал чадах болов уу? гэж бодож явтал хоёр дүү минь тэр морьдыг барьж үзэх гэхэд нь би ойртуулсангүй. Тэгээд цааш явтал “Том Жерри хоёр” киноны Том муур Жеррийг шүүрээр цохих гэж байгаа зураг байлаа.



Энхбаяр Томыг хараад:

- Ах аа, энэ Томыг хараач гэж хэлэнгүүтээ л зангидсан гараараа цохиод автал Томын зураг цөмрөөд онгойсон нүх болчхов. Хэдийдээ ч мэдчихсэн юм, нөгөө эгч гүйж ирмэгцээ дуу алдан, миний мөрнөөс барьж аваад:

- Түүрүүн баримал эвдсэн, одоо бас... Та нар чинь яасан хачин хүүхдүүд вэ? Зүгээр юм үзээд гарч чадахгүй! гэж чангаар загнахад үзэсгэлэн үзэж явсан хүүхдүүд ээж аавтайгаа



“яачихсан юм бол” гэсэн шиг бие биенээ түлхэн биднийг бүчлээ. Нөгөө эгч:

- Эднийг харж бай! Битгий явуулаарай! гэж тойрсон хүүхдүүдэд захиад хаашаа ч юм, олон хүмүүс дундуур орон алга болов. Хүүхдүүдийн аав ээж нар:

- Ийм жаахан хүүхдүүдээ харах хандах хүнгүй, ингээд явуулчхаж байдаг яасан хачин эцэг эхчүүд вэ?

- Хүү минь аав ээж чинь хаана байна?

- Чи сургуульд орсон уу?

- Хэддүгээр анги вэ? гэлцэн тал талаас шахан, зарим нь бид нар луу улам дөхөн асууж шалгаав. Би хэнд нь юу гэж хэлэхээ мэдэхгүй хоёр дүүгийнхээ толгойг тэврээд уйлчлав. Тэгтэл нөгөө эгч аравдугаар ангийн болов уу гэмээр нэг том ахыг дагуулан хүрч ирэн хүмүүсийг жаал зайчлаад,

- Баатар аа, чи үүнийг хараач. Энэ нөхдүүд зургийг чинь ингээд урчихлаа гэхэд эргэн тойронд байгаа хүмүүс юу хэлэхийг нь хүлээн чимээгүй болов. Би тэр ахыг зураг уруугаа харамсаж буйг хараад, “Энэ ах бид гурвыг яах бол” гэж бодон хоёр дүүгээ улам чанга тэврээд зогсож байв. Нөгөө ах биднийг хараад зургаа бас нэг харснаа харц нь зөөлрөн,

- За, ах нь та гуравт их баярлалаа гэж миний толгойг илээд, их л баярласан янзтай инээмсэглэлээ. Би ч тэгж хэлнэ гэж бодоогүй болохоор нулимстай нүдээр өөдөөс нь гайхан харахад нөгөө ах надаас:

- Энэ зургийг та гурвын хэн нь ингэв? гэхэд нь дахин түгшүүр төрөн:

- Дүүгээсээ өрсөн “би” гэж сулхан дуугарахад инээмсэглэж:

- Та нарт их баярлалаа гэж хэлчхээд зургаа аваад яваад өгөв. Нөгөө эгч үрүү харахад надтай адил гайхаж байгаа бололтой. Би ч дүү нараа дагуулан бушуухан үзэсгэлэнгийн танхимаас гарч гэрийн зүг яаран явлаа.

Замдаа яагаад тэр ах биднийг загнахгүй, “Баярлалаа” гэж хэлсэн юм бол? гэж бодсоор гэртээ ирэхэд аав ээж хоёр:

- За сайхан юм үзэв үү? гэж асуусаар утгав.

Тэр ах зургийг нь цөм цохичихсонд яагаад тэгтэл баярласан юм бол доо?...

1985 он




Хэний буруу вэ?

Хүүхэлдэйн кино эхэлчихсэн үү? Ааваа! гэж хашгирсаар гаднаас гүйхээрээ орж ирсэн Баяраа зочныхоо өрөө үрүү орчхов.

- Хүүе, Баяраа! Наад хувцас, хунараа тайлаач! гэж аав нь дуудсан боловч тэр тоосонгүй, шууд л зурагтаа асаав. Хүүхэлдэйн киноны дуу хангинаж, дүрс гарч ирэх үед аав нь түүний дэргэд ирээд,

- Чи чинь цэвэрлэсэн дэвсгэр дээгүүр шавхайтай гутлаараа туучихаас зовохгүй байна уу? гэж хэлээд, түүнийг хөтлөн угаалгын өрөөнд орлоо.



Баяраг усанд ороод гарч ирэхэд кино аль хэдийн дуусчихжээ. Баяраа аавдаа уурлан өрөөндөө гүйж ороод, орон дээрээ түрүүлгээ хараад хэвтчихлээ. "Маргааш хичээлийн завсарлагаанаар хүүхдүүд хүүхэлдэйн киногоо ярьж гарна. Тэгэхэд би аваас болоод үзэж чадсангүй. Миний хувцас шавхай болсноос ямар бие болсон биш. Аав миний хувцсыг тайлаад угаачхаж болох л байсан шүү дээ гэж бодоод цухалдан хэвтэж байтал аав нь ирээд:

- Аавын хүү босч хоолоо идээд, хичээлээ давтчихаад унт. Ингэж уурлаад даалгавраа хийхгүй бол чамд л муу шүү дээ. Өвөө нь миний хүүд юу гэж захидаг билээ гэж аргадсан боловч Баяраа уурлаж хэвтсээр байгаад унтчихжээ.



Ангийн багш хичээлээ зааж дуусаад:

- За хүүхдүүдээ, гэрийн даалгавраа шалгуулцгаа. Хийгээгүй нь хичээлийн дараа нөхөж хийнэ шүү гэхэд Баяраагийн дотор пал хийгээл явчихлаа. Одоо яах билээ ээжийгээ угтах минь ч өнгөрчээ. Аавыг хэлээд байхад нь уурлаж хэвтэхийн оронд даалгавраа хийдэг байж. Тэгсэн бол одоо аавтайгаа хоёулаа машиндаа суугаад онгоцны буудал уруу давхихгүй юу. Ээж надад компьютер авч ирнэ гэсэн. Шавхай туучсанаас болоод хүүхэлдэйн кино үзэж чадаагүй, тэгээд бас кино үзүүлсэнгүй гэж аавдаа уурласаар байгаад даалгавраа хийгээгүй. Бас түүнээс болоод ээжийгээ угтаж чадахгүй нь. Ээж явахдаа,



“Ирэхэд хүүтэйгээ хоёулаа угтаарай” гэсэн шүү дээ. Баярааг ингэж бодож байтал багш нь:

- Баяраа дэвтрээ аваад ир. Чи бид хоёр хоёулхнаа үлдчихлээ, гэлээ. Баяраа “За одоо ч өнгөрчээ. Ээжийгээ тосох нь битгий хэл өнөөдөр бүр оройтож очих нь дээ гэж бодсоор хөлөө арай ядан зөөж, багшдаа дэвтрээ аваачиж өглөө. Багш дэвтрийн хуудсуудыг эргүүлж үзээд:

- Чи чинь ангиасаа ганцаараа даалгавраа хийгээгүй байна шүү дээ. За яахав, анх удаа юм байна гээд анхаарал тавилаа шүү! Дахиж хийхгүй ирж болохгүйг мэдэж байгаа биз дээ гэхэд Баяраа:

- Тэгэлгүй яахав багш аа, би заавал хийж ирнэ гээд цүнхээ шүүрэн авч ангиасаа гүйн гарлаа. Сургуулийнхаа хаалгаар түүнийг гарч ирэхэд аавынх нь машин дөнгөж ирж байв. Ингээд Баяраа аавтайгаа онгоцны буудал уруу хурдаллаа.

1982 он. 2-р анги

Цагаандай Цоохондой хоёр

Бага үдийн алдад миний дайгдаж явах машин ирлээ. Жолооч ахыг гэрт орж цай уух зуур би Цагаандай Цоохондой хоёрыг угжив. Явахынхаа өмнө тэдний хөөрхөн зөөлөн хошууг хацартаа нааж эрхлүүлэн, өөрөө эмээ өвөөдөө үнсүүллээ. Машины зүг явахад өнөө хоёр маань дээлийн хормойноос зууж татах нь холгүй даган шогшиж, Цоохондой нь хөлийн хоорондуур шурган гарч ирээд өвдөг өөд цоройж байлаа. Би барьж явсан ууттайгаа өвөөдөө өгөөд хоёр ишгээ ээлжлэн тэвэрч эрхлүүлэв. Ишиг хурга цөм л эхийгээ хараад майлдаг бол Цагаандай Цоохондой хоёр намайг хараад цовхорч дэвхрэн гүйж ирээд урдуур хойгуур тоглож, гар хуруу долоож, эрүүгээ дэвсэн, чих мулцгаа маажуулна. Ер намайг хаашаа л хандана



дагаж гүйлдэнэ. Би Цагаандай Цоохондой хоёрыгоо бодохоос буугаад үлдчихмээр санагдав. Тэд надаас ямар нэг юм гуйх мэт хошуугаа өлийлгөн миний зүг хараад, өвөөгийн хажууд зогсож хоцорлоо. Эмээ миний хойноос сүү өргөх гээд Цагаандайг гишгэх шахав. Намайг гар далласаар хөдлөхөд Цагаандай Цоохондой хоёр эмээ өвөө хоёрыг минь даган машины хажууд шогшиж яваа нь харагдлаа. Нэлээд яваад жолооч ах ам нээж,

- Чи чинь уйлаад байна уу даа? Ээж аавдаа очих гэж байгаа эр хүн байж. Хойтон хавар сургуулиа тараад эргээд л ирнэ шүү дээ. Танай өвөө эмээ хоёр ануухан улсууд, алзахгүй дээ гэв. Би:

- Өвөө эмээдээ ч яахав эргээд ирнэ л дээ. Харин Цагаандай Цоохондой хоёрыгоо л их санах байх даа гэхэд жолооч ах тэд чинь юу билээ? гэв.

- Сая намайг дагаад байсан ишигнүүд байхгүй юу.

- Чи тэгээд өвөө эмээдээ биш, ишгэнд хоргодоод уйлаад байгаа юм уу? Би нэг хэсэгтээ дуугарч чадсангүй. Тэднийг би л угжиж эрхлүүлсээр байгаад өөртөө дасгачихсан юм чинь. Хэсэг явж байгаад жолоочид өнгөрсөн зуныхаа адал явдлыг ярьж өгмөөр санагдаад,

- Ах аа би танд Цагаандай Цоохондой хоёрынхоо тухай ярьж өгөх үү? гэхэд жолооч:

- Тэгээч, юм ярьж явахад зам амархан хорогддог юм гэв.

- Ноднин жил намайг өвөөгийндөө ирэхэд гэрийнх нь бүрээс энд тэндээ урагдаж цоороод бүүр ноорчихсон байлаа. Би бүр гайхаж өвөөгөөс яагаад ийм болсныг асуувал:

- Манай мухар хар ямаа зөнөглөж гэрийн бүрээс тэсгээхээ байсан юм аа гэв. Өвөөгийн минь гэрийг урж идсэн тэр муу хар ямааг болгож тавья гэж бодоод тэр хар ямааг хаана байгааг өвөөгөөсөө асуутал:

- Бэлчээрт яваа, одоохон ирнэ гэв. Удалгүй эмээ хонио туусаар хойд энгэр дээгүүр гарч ирлээ. Тэгтэл өвөөгийн хар



ямаа ганцаараа наашаа давхиж ирээд миний барьж ирсэн бортоготой ус уруу хошуугаа шургуулан ууж гарав. Түүнийг сахлаас нь угзарч байж хойш нь түлхтэл, ухарч ухарч өрөөсөн өвдөг үрүү мөргөөд авлаа. Би түүнээс зайлах гээд чадалгүй ойчиж өвдсөндөө уйллаа. Эмээ өвөө хоёр сүйд болон гайтай хар ямааг хөөж, би ч эмээдээ хөтлүүлэн гэртээ орлоо. Түүнээс хойш хар ямааг гэгсгээх бодол минь үгүй болж, хар ямаа ч өвөөд хөөгдөөд хэд хоног гэрт орсонгүй. Гэлээ ч бид аажмаар дасан, сүүлдээ бүр хөөцөлдөж тоглодог болов. Ингээд би өвөө эмээгийнхээ “Мэхээрэн эвэрт” гэж нэрлэдэг шинэ найзтай болов. Би Мэхээрэн эвэрттэйгээ чихэр боов юу л олдоно, хувааж иднэ. Тэр ч миний хуруу гарыг долоож, хаашаа л хандана дагаж явдаг болов. Сүүлд нь хотод очсон хойноо ч хар ямаагаа үе үе санадаг байлаа. Энэ зун амралтаараа ирэхэд Мэхээрэн эвэртгийн маань гэдэс цүлхийж унжаад бүүр том болчихож. Түүний ишиглэх гэж байгааг өвөө эмээ хоёроос мэдлээ. Өвөө:

- Хар дамшиг чинь хужирсаад тэр үү гэрийн бүрээс урдаг хэвээрээ шүү. Тэгээд ч зогсохгүй гадаа тавьсан аарц, шахсан бяслагны уут хүртэл урж идээд, айл амьганд ад болж байна гэж



ярьж байлаа. Нэг өдөр эмээ тогоо нэрээд завгүй. Би гишүү хугалж эмээдээ туслах гэж байтал нөгөөдөх чинь гэрт ороод зуугийн хавчигтай элдүүрийн гантай уснаас дунд нь ортол уучихсан байлаа. Эмээ бид хоёр хамжиж байж арай л гэж гэрээс гаргав. Эмээ:

- Хар дамшиг чинь мөрөөрөө үхэхгүй түлэгдэж үхэх вий дээ гэсээр бэлчээр лүү нь туугаад явуулчихлаа. Орой нь тэр бэлчээрээс ирсэнгүй. Өвөө “Хаашаа явчихдаг хар гайхал вэ? Чоно нохой дайралдаж осолдоогүй байгаа даа” гэж эмээтэй ярилцаад эрэлд явлаа. Тэр өдөр олдсонгүй. Маргааш нь өглөө эрт намайг босоогүй байхад өвөө дахиад л эрэлд явсан байв. Үдийн алдад чихнийхээ доод талд мулцагтай хоёр хөөрхөн ишиг дүүрсээр хүрч ирлээ. Цагаан алаг толгойтой хар, нөгөөх нь хар цоохор толгойтой алаг ишиг байлаа. Эмээ минь, өвөөгөөс:



- Муу хар ямаа минь яасан бэ? гэж асуухад өвөө хэсэг дуугүй байснаа,

- Хээр ишиглээд өөрөө үхчихсэн байна. Нэг нь гүрээнд нь хошуугаа хийгээд унтчихсан, энэ цоохор дамшиг хөхийг нь үмхчихсэн сүүлээ хөдөлгөөд байж байна. Өрөвдмөөр гэдэг нь гэв. Эмээ гарынхаа алгаар нүдээ арчаад дуугүйхэн эргээд гэртээ орчихлоо. Би тэссэнгүй Мэхээрэн эвэртийгээ өрөвдөөд уйлчлав. “Амьтан болгонд л ад үзэгддэг байсан даа” гэж өвөө минь хэлээд намайг аргадаж,

- Уйлаад яахав дээ, миний хүү. Их сүүтэй ямааны удам юм сан. Хөгширсөн юм даа, зайлуул. Өөрөө үхэхдээ бас ийм хоёр амьтан үлдээдэг байна шүү гээд өвөө хөмсгөө зангидан хэсэг чимээгүй байж байж, хөгшин болсон амьтан гэдэг чинь нэг л өдөр ингээд пөөдийгөөд өгдөг юм байна шүү дээ. Миний

хүү угжиж байгаад мал болгочихыг бод. Эхээсээ дутахгүй дамшигнууд болно вий гэж хэлээд хоёр ишигийг надад тэврүүлэв. Ингээд би хоёр ишгэндээ Цагаандай, Цоохондой гэж нэр өглөө. Угж нь таараад тэрүү, амархан хөрвөжсөн. Та сая харсан шүү дээ. Одоо тэднийг над шиг эрхлүүлж тоглох хүн байхгүй. Хурга ишигтэй хонь ямаа гувших гээд ад үзэгдэж, мөргүүлээд хэцүүдэх байх даа. Угаасаа гувшаа амьтад байгаа юм гэж намайг ярихад жолооч ах:

- Өө хөөрхий. Тэр хоёр ишиг чинь эхгүй юм бий. Гэвч зүгээр ээ. Чи санаагаа зовоогоод хэрэггүй. Өвөө эмээ хоёр нь гэж хашир улсууд байхад юунд санаа зовох вэ. Чи хойтон хавар хүрээд ирэхдээ тун мэдээтэй байхгүй бол чамайг хоёр талаас чинь хавсайдаж өргөөд гөдройтуулж мэдэх томоо ямаа болчихсон байх вий. Чи харж л байгаарай! гээд инээхэд нь би ч бас инээчихлээ.

Буушуухан хойтон хавар болоосой. Цагаандай Цоохондой хоёртоо мөргүүлж тоглох юм сан. Харин тэд намайг таних болов уу?...

1991 он

Сансарт ниссэн минь

Манай сургууль сансарын хөлөг хөөргөх гэж байгаа гэж дулаад Нямаа Отгоо бид гурав гүйж очлоо. Багш нар тэнд цугларчхаад аль ангийн хэн хэнийг нисгэх тухай ярилцаж байлаа. Тэгтэл захирал багш, бид гурвыг дуудаж:

- Энэ гурвыг нисгэе. Маргалдаад байх юмгүй гэхэд ангийн багш баярлан:

- Манай ангийн урдаа барьдаг гурван хүү гэж магтаад бид гуравт сансарын нисгэгчийн хувцас өмсүүлж байтал хэн нэг нь:



- 3-ын А-гийнхан улаан нооль гурван юмаа, урдаа барьдаг гэнэ ээ гэх нь дуулдав. Тэгэхээр нь би захирал багшийг “Тэгвэл больё. Наад хувцсыг нь тайлуул” гэх болов уу гэхээс айж байлаа. Тэгтэл захирал багш:

- Хувцсыг нь яаралгүй өмсүүлж сайн янзалж өгөөрэй. Та нар айхгүй юм байгаа биз дээ гэхэд нь бид гурав:

- Айхгүй гэлээ. Багш нар бид гурвыг хөтлөн, хөлгийн дэргэд хүргээд:

- За одоо орцгоо. Зоригтой сайн хүүхдүүд байна. Сайн яваад ирээрэй! гээд биднийг бүхээг үрүү оруулаад сандал дээр бөхөллөө.

Газраас тасрахад их доргисон учир бид их айцгаав. Нэг мэдсэн, толгой доошоо болчихсон үй олон одод дундуур хөвж явлаа. Оддыг түүгээд өвөртөлчихмөөр ойрхон харагдана. Бид гурав удалгүй дасч, зориг ороод ийшээ тийшээ хөвж хөөцөлдөн удаан тоглов. Тэгтэл бидэнтэй адилхан хувцастай нэг хүн манай хөлөг дотор ороод ирчихсэн хөвж яваа нь харагдлаа. Бид гурав түүнээс айж зугтаагаад өрөөнд орж, хаалгаа түгжээд яахаа мэдэхгүй сандарцаалаа. Үүд дуугармагц би Нямаад газарт

мэдэгд! гэж дохио өглөө. Нямааг дуу сонсогддоггүй бүхээгт орон газартай холбоо барьж байтал нөгөө хүн бидний хойноос ороод ирчихсэн,

- Танай хөлөг одоо хорин минут болоод буух нь шив дээ гээд ннээмсэглэхэд би сандарсандаа хэлэх үгээ олохгүй дэмий л,

- Одоо хэдэн цаг болж байна?" гэв. Тэр ах:

- Арван хоёр цаг хорин минут болж байна. Та нар огторгуйд цаг хорин минут нисээд байна гээд Отгоотой хөөцөлдөж тоглолоо. Би бүр гайхаж, Отгоогоос,

- Энэ юун хүн бэ? гэж асуувал,


- Болгарын хөлгөөс орж ирсэн юм. Манай монголд ажиллаж байсан, монгол хэл сайн мэддэг хүн гэнэ ээ. Сансарт дэлхийнхээ хүнтэй уулзахаар хүүхдийн оюун ухаанд хэр зэрэг нөлөөлөх нь вэ гэдгийг судлахаар эдний хөлгийг манай хөлөгтэй зэрэг нисгэсэн юм байх. Манай хөлгийг гаднаас нь онгойдог хаалгатай хийсэн юм байна гэлээ. Отгоогийн ярьсныг Нямаа бүхээгнээс гарч ирээд надад хэлэв. Одоо л сайн харвал манай сургууль дээр ирж бид нартай уулзалт хийж байсан хүн байлаа. Бид нар бүгдээрээ хөөцөлдөж тоглолоо. Бид нарын сансарт тоглохыг ч гэсэн судлах байх даа гэж бодож байтал "Гарах боллоо" гэсэн дохио өгч, болгар ах хөлөг үрүүгээ явж бид ч газардахад бэлдлээ. Амжилттай газардлаа. Биднийг бүхээгнээсээ гарч ирэхэд багш бидний хөлсийг арчиж өгөөд,

- Халууцав уу? Ямар байна. Гоё байгаа биз дээ гэхэд нь бид гурав ам амаа уралдуулан:

- Ёстой гоё. Харин жоохон баймаар л байлаа гэж ярилцаар хувцсаа сольж өмсөцгөөв. Гэтэл захирал орж ирээд:

- За хүүхдүүд ээ! Одоо хурлын зааланд очигцоо. Анх удаа та нар сансарт нисч үзсэн болохоор сэтгэгдлийг чинь сонсохоор хүүхдүүд, багш нар хүлээж байгаа.

Биднийг очиход танхим дүүрэн хүүхэд байсан ч манай



байрны нэг ч хүүхэд алга. Бас гэрээс ч хүн алга. Бидэнд анхны сансрын нисгэгч гэсэн тэмдэг өгөхөд нь бүгдээрээ баярлан, хурлын залнаас гарч ирэхэд Эрдэнээ ах над уруу ирээд:

- Сансарт нисэх гоё юм уу?
- Ёстой гоё юм. Ээж ирээгүй юм уу?

- Ээж ажил дээрээ байгаа. Чи чинь сургуулийн сансрын танхимд орж үзчихээд жинхэнэ сансарт ниссэн гэж бодоод байгаа юм уу даа. Танхимын нээлтийн хамгийн анхныхад нь та хэд суусан болохоор цуглаан хийж та нарт тэмдэг өгсөн юм. Ахын дүү гэртээ харь. Би сансрын хөлөгт орж үзнэ ээ гээд гүйгээд явчихлаа. Ээжийгээ энэ хөлөгт суулгаж үзүүлэхсэн. Ээж минь ямар их баярлах бол! гэж бодсоор гэр лүүгээ яаран гүйлээ.

1983 он. 3-р анги



Ганаа гэж...

Манай байрны Ганаа гэж нэг их сахилгагүй жаал байдаг юм. Түүнийг ганцхан манай байрныхан төдийгүй ойр хавийнхан ч бас анддаггүй. Тэр нэг удаа цонхных нь дор нарлаж байсан эмээ нарын дээрээс ус асгаж дүрсгүйтэхийг нь бид харсан юм. Тэгтэл нөгөө эмээ нар аавыг нь орой ажлаасаа ирэхэд

нь хэллээ. Аав нь гэртээ ороод нэлээд удсаны дараа Ганаа нүдэндээ нулимстай ч гэсэн инээмсэглэсээр гарч ирэхэд, нөгөө эмээ нарын нэг нь:

-За, алганбоовамттай байна уу? Дахиж дүрсгүйтэж болохгүй шүү гэхэд Ганаа нулимсаа арчин, зальтай инээмсэглэж,

- Аав намайг та нарын дээрээс ус асгалаа гэж биш харин цонхон дээрээс унаж үхэх нь үү? гэж алган боов өгсөн юм чинь гэхэд нөгөө эмээ нар бүгд л инээлдэцгээж билээ.

Бас саяхан нэг өдөр Пүүжээ, Билгүүнээ, Тамираа бид нарыг элсээр гэр, машин, зам, уул барьж тоглож байтал Ганаа ирээд тэр бүгдийг минь няц гишгэлээд яваад өгөв. Бид нар уурлаж түүний араас гүйж очоод,





- Чи ягаад бидний тоглож байсан тоглоомыг эвдчихэв? гэхэд Ганаа:

- Би та нарт тэрнээс сонин юм үзүүлэх гэсэн юм. Намайг дагаад явцгаа. Тэгээд намайг ямар мундаг хүүхэд болохыг үзэх болно гэв. Бид ч юу үзүүлэх юм бол гэж сонирхон, түүнийг даган гүйлдлээ. Ганаа байшингийн өнцөг дэх борооны усан хоолойн дэргэд очоод түүнийг алгадан:

- За би үүгээр авираад байшин дээр гарна гэж ташаа тулан онгиров. Бид нар түүнийг хуурч гэж бодоод:



- За чи бас бид нарыг залилах санаатай юу? Бидний тоглоомыг байснаар нь түргэн хийж өг гэж шаардахад Ганаа:

- Би та нарыг хуураагүй дээ, худлаа гэвэл та нар харж бай! гээд дээш авирлаа. Бид ч түүнийг уначих вий гэж айсандаа доошоо буу, буу! Ганаа битгий гэсэн боловч тэр улам хурдан авирлаа. Орцноос гарч ирсэн Номингийн эмээ түүнийг хараад:

- Хөөе! чи чинь яаж байгаа хүүхэд вэ? Унаж үхэх гээ юу? Хурдан доошоо буу! гэхэд Ганаа:

- Зүгээр ээ, эмээ. Би энэ байтугай юмыг ч чадна гэгчхээд дээш авирахад нь эмээ толгой сэгсрэн:

- Яасан тархигүй хүүхэд вэ? Наад хоолой чинь залгаасаараа салаад унавал чи хөл гараа гэмтээнэ шүү гэж хэлж дуусаагүй байтал Ганаа усны хоолойтой хамт тар нярхийн уналаа. Эмээ ч,

-Тэгнэ ээ тэр гэж дуу алдан очоод гараас нь татан босгоход Ганаа өвдсөндөө болоод уйлан завдахад нь бид нар түүнийг хараад инээлдчихэв. Ганаа ч ичсэндээ эмээгээс гараа угз татан аваад гэртээ орохоор хөлөө барин догонцсоор яваад өгөв.

Ганаа гэж... ийм л жаал байгаа юм даа.



Гарчиг

Үзэсгэлэнд болсон явдал	3
Хэний буруу вэ?	9
Цагаандай цоохондой хоёр	13
Сансарт ниссэн минь	18
Ганаа гэж... ..	22



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.